

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнхангай сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/131/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М. Батсуурь

Утас: 70453317

Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М. Бат-Амгалан

Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит

ХХК-ийн аудитор:

Ч.Сэлэнгэ

Утас: 9902-3656

Цахим хаяг: ariuntugsorshihuaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНХАНГАЙ СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

2023.02.24 № ᠑8᠕-2023/131/ТД - СЛН - ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнхангай сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнхангай сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200202

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52,088,422.71</u>	<u>69,095,454.53</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	9,261,736.62
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	9,261,736.62
3121	Төгрөг	00.00	9,261,736.62
31211	Төрийн сангийн харилцах	00.00	9,261,736.62
33	АВЛАГА	14,900,319.80	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,900,319.80	00.00
335	Бусад авлага	12,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	12,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37,188,102.91	59,833,717.91
354	Хангамжийн материал	37,188,102.91	59,833,717.91
35410	Бичиг хэргийн материал	844,600.00	1,740,890.00
35420	Аж ахуйн материал	29,381,072.95	47,241,847.95
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	14.31	14.31
35460	Хүнсний материал	6,962,415.65	10,850,965.65
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>809,352,398.54</u>	<u>773,670,593.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	809,352,398.54	773,670,593.37
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	797,396,398.54	761,714,593.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	816,078,063.47	816,078,063.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-77,194,557.62	-107,673,600.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,294,495.00	60,294,495.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,802,185.67	-38,625,012.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,824,804.87	35,024,804.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,303,972.54	-22,594,215.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,933,024.00	22,666,024.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,450,427.97	-6,723,120.33
39217	Ном	3,017,155.00	3,267,155.00

393	Биет бус хөрөнгө	11,956,000.00	11,956,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,956,000.00	11,956,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>861,440,821.25</u>	<u>842,766,047.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>19,685.67</u>	<u>149,005.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,685.67	149,005.00
413	Өглөг	19,685.67	149,005.00
4136	Бусад өглөг	19,685.67	149,005.00
41361	Байгууллагад төлөх өглөг	19,685.67	149,005.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>861,421,135.58</u>	<u>842,617,042.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	861,421,135.58	842,617,042.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	188,657,582.01	188,657,582.01
51101	Өмч: - төрийн	188,657,582.01	188,657,582.01
51102	- хувийн	00.00	00.00
51103	- хувьцаат	00.00	00.00
51104	Халаасны хувьцаа	00.00	00.00
51105	Нэмж төлөгдсөн капитал	00.00	00.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00.00	00.00
512	Хуримтлагдсан үр дүн	282,055,088.22	263,250,995.54
51210	Өмнөх үеийн үр дүн	282,055,088.22	282,055,088.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-18,804,092.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	390,708,465.35	390,708,465.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>861,440,821.25</u>	<u>842,766,047.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	292,576,900.00	329,834,640.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	261,247,600.00	10,700,335.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,200,000.00	10,700,335.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,200,000.00	10,700,335.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,200,000.00	10,700,335.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,329,300.00	319,134,305.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	274,388,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	274,388,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	44,746,205.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	44,746,205.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	288,171,235.45	348,638,732.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,171,235.45	348,638,732.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,201,861.72	348,638,722.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,957,420.35	210,576,271.96
210101	Үндсэн цалин	130,203,491.35	155,999,050.25
210102	Нэмэгдэл	16,171,477.00	44,202,788.00
210104	Урамшуулал	16,397,869.00	8,775,796.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,184,583.00	1,598,637.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,011,829.59	25,994,729.88
210201	Тэтгэврийн даатгал	15,996,076.08	18,168,633.77
210202	Тэтгэмжийн даатгал	1,768,028.21	2,137,509.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,386,789.13	1,682,808.21
210204	Ажилгүйдлийн даатгал	313,901.68	357,312.01
210205	Эрүүл мэндийн даатгал	3,547,034.49	3,648,466.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,558,807.20	30,498,294.20
210301	Гэрэл, цахилгаан	1,461,480.00	2,215,072.00
210302	Түлш, халаалт	28,097,327.20	27,938,222.20
210303	Цэвэр, бохир ус	00.00	345,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,794,220.00	1,150,560.00

210401	Бичиг хэрэг	939,620.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,828,500.00	1,114,560.00
2105	Нормативт зардал	11,585,660.00	31,066,360.00
210502	Хоол, хүнс	10,406,360.00	30,896,360.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	845,000.00	170,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,405,400.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,405,400.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	785,000.00	520,406.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,000.00	520,406.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,781,524.58	48,032,100.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,803,295.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,322,600.00	1,364,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,458,924.58	41,864,805.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,969,373.73	10.47
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,469,373.73	10.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,469,373.73	10.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>4,405,664.55</u>	<u>-18,804,092.68</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>3,943,488.57</u>	<u>-18,804,092.68</u>

210604	Урсгал засвар	1,123,500.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	785,000.00	520,406.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,000.00	520,406.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,045,000.00	7,994,585.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,295,895.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,045,000.00	2,698,690.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,969,373.73	10.47
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,469,373.73	10.47
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,469,373.73	10.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,000,000.00</u>	<u>10,994,736.62</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,733,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,733,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,733,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,733,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-1,733,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,000,000.00	9,261,736.62
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,000,000.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	9,261,736.62

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01 рх үлдэгдэл	188,657,582.01	390,708,465.35	282,055,088.22	861,421,135.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	188,657,582.01	390,708,465.35	282,055,088.22	861,421,135.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,804,092.68	-18,804,092.68
D09	2022 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	188,657,582.01	390,708,465.35	263,250,995.54	842,617,042.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	274,388,100.00	265,126,363.38	9,261,736.62	96.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,388,100.00	265,126,363.38	9,261,736.62	96.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274,388,100.00	265,126,363.38	9,261,736.62	96.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,716,700.00	195,547,340.20	8,169,359.80	95.9%
210101	Үндсэн цалин	155,046,700.00	144,268,980.20	10,777,719.80	93.0%
210102	Нэмэгдэл	46,372,500.00	43,378,300.00	2,994,200.00	93.5%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	0.00	
210104	Урамшуулал	2,297,500.00	7,900,060.00	-5,602,560.00	343.8%
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	0.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,564,000.00	24,546,122.18	1,017,877.82	96%
210201	Тэтгэврийн даатгал	17,498,000.00	16,983,953.49	514,046.51	97%
210202	Тэтгэмжийн даатгал	2,016,500.00	1,998,146.91	18,353.09	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,613,200.00	1,595,137.56	18,062.44	98.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	403,300.00	375,212.05	28,087.95	93%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,033,000.00	3,593,672.17	439,327.83	89%
2105	Нормативт зардал	34,786,200.00	34,784,910.00	1,290.00	99.9%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	0.00	
210502	Хоол, хүнс	34,786,200.00	34,784,910.00	1,290.00	99.9%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	520,406.00	71,594.00	87.9%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	520,406.00	71,594.00	87.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9729200.00	9727585.00	1,615.00	99.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,029,200.00	7,028,895.00	305.00	99.9%

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,700,000.00	2,698,690.00	1,310.00	99.9%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	274,388,100.00	274,388,100.00	0.00	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	274,388,100.00	274,388,100.00	0.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	274,388,100.00	274,388,100.00		100%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,261,736.62		

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,746,500.00	44,746,194.53	10.47	99.99%
УРСГАЛ ЗАРДАЛ	44,746,500.00	44,746,194.53	10.47	99.99%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,746,500.00	44,746,194.53	10.47	99.99%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,148,400.00	12,148,297.66	102.34	99.99%
Үндсэн цалин	10,468,400.00	8,849,435.95	1,618,964.05	84.5%
Нэмэгдэл		824,488.00	(824,488.00)	
Урамшуулал		875,736.00	(875,736.00)	
Гэрээт ажлын хөлс	1,680,000.00	1,598,637.71	81,362.29	95.2%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,448,800.00	1,448,607.67	192.33	100%
Тэтгэврийн даатгал	1,026,900.00	1,026,921.18	-21.1	100%
Тэтгэмжийн даатгал	120,800.00	120,814.24	-14.24	100%
ҮОМШӨ-ний даатгал	96,700.00	96,651.40	48.6	99.9%
Ажилгүйдлийн даатгал	18,600.00	18,565.54	34.46	99.8%
Эрүүл мэндийн даатгал	185,800.00	185,655.31	144.69	99.9%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зарлал	30,349,300.00	30,349,289.20	10.8	100%
Гэрэл цахилгэан	2,050,000.00	2,479,313.00	(429,313.00)	120.9%
Түлш, халааят	27,573,300.00	27,524,976.20	48,323.80	99.8%
Цэвэр бочир ус	726,000.00	345,000.0	381,000.00	47.5%
Эд хогшил худалдан авах	800,000.00	800,000.00		100%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,746,500.00	44,746,489.53	10.47	99.99%
Орон нутгийн төсвөөс	44,746,500.00	44,746,489.53	10.47	99.99%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнхангай сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Энэхүү чиг үүргийн хүрээнд тус цэцэрлэг нь "Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" зорилго дэвшүүлэн "Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, хүүхэд сурах, хөгжих тэгш боломжийг бүрдүүлэн сургалтын чанар, үр дүнд ахиц гаргана" гэсэн зорилт тавин ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнхангай сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,674.8 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		9,261.7	9,261.7
Авлага	14,900.3	0	-14,900.3
Бараа материал	37,188.1	59,833.7	22,645.6
Үндсэн хөрөнгө	797,396.4	761,714.6	-35,681.8
Нийт хөрөнгө	861,440.8	842,766.0	-18,674.8
Өр төлбөр	19.7	149.0	129.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	861,421.1	842,617.0	18,804.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	861,440.8	842,766.0	18,674.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,261.7 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлагын хувьд өмнөх онд ковидын нөхцөл байдалтай холбоотой 2021 оны 12-р сарын 31-нд хөрөнгө хүлээн зөвшөөрөлтийн шалгуур бүрэн хангаагүй байсан учир шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн. Харин 2022 онд хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуурт бүрэн нийцсэн учир авлагыг 14,900.3 мянган төгрөгөөр бууруулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,833.7 мянган төгрөг болж 22,645.6 мянган төгрөгөөр буюу 60.9 хувь өссөн байна. Энэхүү өсөлтөд Шимт боловсролын байгууллагаас нийлүүлсэн 14,000.0 мянган төгрөгийн аж ахуйн материалаар ангилан бүртгэсэн сургалтын хэрэглэгдэхүүн болон үнэ төлбөргүй хүлээн авсан дүн зонхилж нөлөөлсөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 761,714.6 мянган төгрөг болж 35,681.8 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд 5,933.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 41,864.8 мянган төгрөгийн элэгдэл хорогдол тооцсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 842,766.0 мянган төгрөг болж 18,804.1 мянган төгрөг ба 2.2 хувиар буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 501,062.8 мянга төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 226,674.7 мянган төгрөгийг бууруулж, 274,388.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байдлаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 274,388.1 мянга, орон нутгийн төсвөөс 44,846.5 мянга, нийт 319,234.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 274,388.1 мянга, орон нутгийн төсвөөс 44,846.5 мянга, нийт 319,234.6 мянган төгрөгийн төсвийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 309,872.6 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 9,261.7 мянган төгрөгөөр хэмнэж ажилласантай холбоотой байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт-УТ	274,388.1	265,126.3	9,261.7	96.6%
1.1	Эрүүл мэндийг дэмжих	800.0	800.0	0	100%
1.2	Цэцэрлэгийн хүүдийн хоол	34,786.2	34,784.9	1.29	99.99%
1.3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,733.20	1,733.0	0.2	99.98%
1.4	Боловсролын байгууллагын багш, ажилчдын хөгжил	800.0	800.0	0	100%

1.5	Боловсролын стандарт, сургалт	208,182.1	199,018.8	9,163.3	95.59%
1.6	Сургалтын хэвийн үйл, ажиллагаа	28,086.6	27,989.6	97.0	91.1%

Боловсролын стандарт, сургалтын орчин гэсэн хөтөлбөр, арга хэмжээний 9,163.3 мянган төгрөгийн хэмнэлт нь цалингийн зардалтай холбоотой үүссэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнхангай сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баялаг, аудитор С.Эрдэнэчимэг, Ч.Сэлэнгэ, В.Сэлэнгэ нар гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Зүүнхангай сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ариун төгс оршихуй аудит” ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан үр дүнгийн тайлангийн нийт зардал 268,727.5 төгрөгийн 1 хувиар буюу 2,687.2 төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан. Гүйцэтгэлийн шатанд энэхүү нөхцөл байдал оршин байхгүй болсон учир дахин шинэчлэн тогтоосон болно. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 348,638.7 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 3,486.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,789.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 116 мэдээллээс хугацаандаа оруулсан 110, хугацаа хоцорч оруулсан 4, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зүүнхангай сумын цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа нь харилцан адилгүй ялгаатай байсан бөгөөд уг хугацаа нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогод нарийвчлан тусгагдаагүй байна.

Үүнтэй холбоотой байгууллагын одоогийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай байна.

Тус цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тайлант хугацаанд 126,007.1 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 87,558.7 мянган төгрөгийн худалдан авалт нь и-баримтаар баталгаажаагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ийн АУДИТОР /Ч.СЭЛЭНГЭ/

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр